



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

СБА-2022/44/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Баруун-Урт сум

2022 он

Тэргүүлэх аудитор: М.Нарантуяа

Утас: 70518369

Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Даваа

Утас: 70512123

Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Аудитор:

А.Мөнхцэцэг

Утас: 70512127

Цахим хаяг: Munkhtsetsega@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Аудитын тайлан.....	7
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
4.1 Зөвлөмж.....	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2022.02.25 № 80

танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМГИЙН ТҮВШИНШИРЭЭ
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Ц.РЕНЧИНМЯДАГ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Түвшинширээ сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Түвшинширээ сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М.Нарантуяа* М.НАРАНТУЯА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>25,053,296.00</u>	<u>36,486,444.63</u>
33	АВЛАГА	6,668,811.00	4,367,543.33
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	1,107,463.33
335	Бусад авлага	6,668,811.00	3,260,080.00
3351	Байгууллагаас авах авлага	6,668,811.00	3,260,080.00
35	БАРАА МАТЕРИАЛ	18,384,485.00	32,118,901.30
354	Хангамжийн материал	12,694,485.00	27,298,901.30
35410	Бичиг хэргийн материал	2,150,686.00	2,932,686.00
35420	Аж ахуйн материал	4,783,095.00	8,122,595.00
35430	Сэлбэг хэрэгсэл	4,511,500.00	4,511,500.00
35440	Түлш, шатах тослох материал	1,249,204.00	1,708,677.30
35470	Бусад хангамжийн материал	00.00	10,023,443.00
35600	Мал амьтад	5,690,000.00	4,820,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>782,705,930.40</u>	<u>1,035,654,570.55</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	782,705,930.40	1,035,654,570.55
392	Биет хөрөнгө	745,939,930.40	998,888,570.55
39201	Барилга, байгууламж, орон сууц	300,435,580.00	412,437,940.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-79,279,148.24	-90,519,116.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	212,954,496.00	367,654,496.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-173,920,219.24	-196,272,238.52
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	178,404,816.48	183,250,866.48
39206	Хуримтлагдсан элэгдэл	-141,880,088.52	-151,514,687.68
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,737,804.77	17,737,804.77
39208	Хуримтлагдсан элэгдэл	-13,409,000.61	-14,628,729.22
39214	Бусад үндсэн хөрөнгө	762,326,991.00	844,067,751.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-317,431,301.24	-373,325,516.28
393	Биет бус хөрөнгө	36,766,000.00	36,766,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	37,166,000.00	37,166,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-400,000.00	-400,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>807,759,226.40</u>	<u>1,072,141,015.18</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>2,840,659.30</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	2,840,659.30
413	Өглөг	00.00	2,840,659.30
4136	Бусад өглөг	00.00	2,840,659.30
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	180,579.30
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	2,660,080.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>807,759,226.40</u>	<u>1,069,300,355.88</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	807,759,226.40	1,069,300,355.88
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	352,745,294.19	352,745,294.19
51101	Өмч: - төрийн	352,745,294.19	352,745,294.19
512	Хуримтлагдсан үр дүн	353,372,093.77	614,913,223.25
51210	Өмнөх үеийн үр дүн	353,372,093.77	353,372,093.77
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	261,541,129.48
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	101,641,838.44	101,641,838.44
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>807,759,226.40</u>	<u>1,072,141,015.18</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	647,780,037.00	865,362,004.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	168,439,174.00	269,736,070.00
120	Нийтлэг татварын бус орлого	168,439,174.00	269,736,070.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	168,439,174.00	269,736,070.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	3,646,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	168,439,174.00	266,089,570.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	479,340,863.00	595,625,934.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	46,614,063.00	131,272,034.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,585,000.00	1,020,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,617,861.00	97,621,008.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,486,202.00	1,237,086.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,925,000.00	31,393,940.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	432,726,800.00	464,353,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	432,726,800.00	464,353,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	552,821,980.09	603,820,874.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	552,821,980.09	603,820,874.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	508,904,502.86	588,326,605.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	248,835,908.77	286,451,358.10
210101	Үндсэн цалин	188,036,377.77	210,629,094.94
210102	Нэмэгдэл	43,352,531.00	50,563,264.06
210104	Урамшуулал	00.00	7,811,999.20
210105	Гэрээт ажлын хөлс	17,447,000.00	17,446,999.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,672,701.00	37,385,702.59
210201	Тэтгэврийн даатгал	23,343,901.00	26,922,002.59
210202	Тэтгэмжийн даатгал	2,476,700.00	2,082,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,384,500.00	2,603,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	488,700.00	520,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,978,900.00	5,257,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,158,124.00	31,324,554.36
210301	Гэрэл, цахилгаан	4,100,000.00	5,050,008.36
210302	Түлш, халаалт	12,058,124.00	12,967,106.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	13,307,440.00
2104	Хангамж, бараа материалын зардал	38,386,396.00	37,216,734.00
210401	Бичиг хэрэг	7,362,850.00	5,626,020.00
210402	Тээвэр, шатахуун	24,369,346.00	28,360,104.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,430,000.00	1,729,290.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,224,200.00	1,501,320.00
2105	Нормативт зардал	2,810,000.00	2,208,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,450,000.00	2,208,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,170,000.00	9,811,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,170,000.00	4,800,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	346,700.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	4,665,000.00
2107	Томилолт, зочны зардал	7,374,962.00	6,173,000.00
210702	Дотоод албан томилолт	7,374,962.00	6,173,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,397,000.00	10,873,576.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,975,200.00	9,298,490.60
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000.00	416,836.00
210803	Даатгалын үйлчилгээ	118,800.00	54,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	274,950.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	364,450.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	00.00	464,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	148,099,411.09	166,881,679.92
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	61,458,239.00	65,795,650.07
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	921,000.00	745,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	85,720,172.09	100,340,529.85

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,917,477.23	15,494,268.95
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,956,948.00	13,914,955.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	6,059,048.00	6,235,355.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	5,878,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	1,801,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,960,529.23	1,579,313.95
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	94,958,056.91	261,541,129.48
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	94,958,056.91	261,541,129.48

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	352,745,294.19	101,641,838.44	295,964,491.21	750,351,623.84
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	352,745,294.19	101,641,838.44	295,964,491.21	750,351,623.84
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-48,295,865.31	-48,295,865.31
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	352,745,294.19	101,641,838.44	353,372,093.77	807,759,226.40
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	352,745,294.19	101,641,838.44	353,372,093.77	807,759,226.40
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	352,745,294.19	101,641,838.44	353,372,093.77	807,759,226.40
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	261,541,129.48	261,541,129.48
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	352,745,294.19	101,641,838.44	614,913,223.25	1,069,300,355.88

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	479,340,863.00	605,941,245.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	3,646,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	3,646,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	3,646,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	3,646,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	479,340,863.00	602,294,745.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	46,614,063.00	137,940,845.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,585,000.00	1,020,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,617,861.00	104,289,819.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,486,202.00	1,237,086.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,925,000.00	31,393,940.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	432,726,800.00	464,353,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	432,726,800.00	464,353,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	473,890,863.00	508,288,745.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	473,890,863.00	508,288,745.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	429,894,345.77	489,576,351.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	253,446,911.77	286,451,358.10
210101	Үндсэн цалин	192,647,380.77	210,629,094.94
210102	Нэмэгдэл	43,352,531.00	50,563,264.06
210104	Урамшуулал	00.00	7,811,999.20
210105	Гэрээт ажлын хөлс	17,447,000.00	17,446,999.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,821,800.00	37,385,702.59

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210201	Тэтгэврийн даатгал	30,493,000.00	26,922,002.59
210202	Тэтгэмжийн даатгал	2,476,700.00	2,082,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,384,500.00	2,603,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	488,700.00	520,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,978,900.00	5,257,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,108,676.00	32,585,840.36
210301	Гэрэл, цахилгаан	4,100,000.00	5,050,008.36
210302	Түлш, халаалт	13,008,676.00	13,246,000.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	14,289,832.00
2104	Хангамж, бараа материалын зардал	36,026,359.00	28,451,531.00
210401	Бичиг хэрэг	5,752,000.00	5,065,000.00
210402	Тээвэр, шатахуун	23,701,360.00	20,039,121.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,300,000.00	1,797,410.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,272,999.00	1,550,000.00
2105	Нормативт зардал	2,650,000.00	1,500,000.00
210502	Хоол, хүнс	1,400,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,250,000.00	1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,593,000.00	9,646,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,593,000.00	4,800,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	346,700.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	4,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	7,374,962.00	6,173,000.00
210702	Дотоод албан томилолт	7,374,962.00	6,173,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,662,000.00	11,265,006.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,240,200.00	10,518,770.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000.00	416,836.00
210803	Даатгалын үйлчилгээ	118,800.00	54,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	274,950.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	57,210,637.00	76,117,213.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	55,989,637.00	75,117,213.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,221,000.00	1,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,996,517.23	18,712,393.95
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,035,988.00	13,873,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	6,138,088.00	6,193,400.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	5,878,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,097,900.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	1,801,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	3,260,080.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	3,260,080.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,960,529.23	1,579,313.95
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	5,450,000.00	97,652,500.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,450,000.00	97,652,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,450,000.00	97,652,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,450,000.00	97,652,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,450,000.00	97,652,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-5,450,000.00	-97,652,500.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	468,000,400.00	466,421,086.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	468,000,400.00	466,421,086.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	454,127,400.00	452,548,086.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	279,885,000.00	279,829,504.10
210101	Үндсэн цалин	198,226,000.00	204,007,240.94
210102	Нэмэгдэл	56,400,000.00	50,563,264.06
210104	Урамшуулал	7,812,000.00	7,811,999.20
210105	Гэрээт ажлын хөлс	17,447,000.00	17,446,999.90

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,794,200.00	35,986,027.59
210201	Тэтгэврийн даатгал	25,598,800.00	25,572,727.59
210202	Тэтгэмжийн даатгал	2,239,000.00	2,082,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,798,900.00	2,603,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	559,800.00	520,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,597,700.00	5,206,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,296,400.00	19,296,008.36
210301	Гэрэл, цахилгаан	6,296,400.00	5,050,008.36
210302	Түлш, халаалт	12,000,000.00	13,246,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,675,000.00	19,571,470.00
210401	Бичиг хэрэг	4,865,000.00	4,865,000.00
210402	Тээвэр, шатахуун	11,400,000.00	11,399,060.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,860,000.00	1,757,410.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,550,000.00	1,550,000.00
2105	Нормативт зардал	1,500,000.00	1,500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,646,700.00	9,646,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,800,000.00	4,800,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	346,700.00	346,700.00
210604	Урсгал засвар	4,500,000.00	4,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	6,173,300.00	6,173,000.00
210702	Дотоод албан томилолт	6,173,300.00	6,173,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,710,300.00	11,265,006.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,519,700.00	10,518,770.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	416,836.00
210803	Даатгалын үйлчилгээ	237,600.00	54,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	303,000.00	274,950.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	69446500.00	69280370.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	68,446,500.00	68,280,370.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	1,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13873000.00	13873000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,873,000.00	13,873,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	6,193,400.00	6,193,400.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,878,600.00	5,878,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,801,000.00	1,801,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	464,353,900.00	466,421,086.05
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	464,353,900.00	462,774,586.05
131001	Улсын төсвөөс санхүүжих	464,353,900.00	462,774,586.05
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	3,646,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	3,646,500.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	134,680,765.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	134,680,765.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	134,680,765.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,621,854.00
210101	Үндсэн цалин	6,621,854.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,399,675.00
210201	Тэтгэврийн даатгал	1,349,275.00
210205	Эрүүл мэндийн даатгал	50,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,289,832.00
210303	Цэвэр, бохир ус	13,289,832.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,880,061.00
210401	Бичиг хэрэг	200,000.00
210402	Тээвэр, шатахуун	8,640,061.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	40,000.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	104489343.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	104,489,343.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	134680765.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	134,680,765.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,020,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	104,289,819.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,237,086.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	28,133,860.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Мөнхцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 1/10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Түвшинширээ сумын Тамгын газар харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах, Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон Тамгын газрын хэлтэс, албадын үйл ажиллагаа уялдуулан зохицуулах, нутгийн захиргааны байгууллагыг чиглүүлэн удирдахад нь Засаг даргад туслах Түвшинширээ сумын ТТЗ-ийн харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн нь хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд нийт ажил гүйлгээний ихэнх хувийг зардлын гүйлгээ эзэлдэг бөгөөд төсвийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байдлыг татвар төлөгч, иргэд илүү анхаардаг учир материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 445.6 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 4.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 3.2 сая төгрөгөөр тогтоосон. Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 264.4 сая төгрөг буюу 32.7 хувиар нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	6.6	4.4	-2.2
Бараа материал	18.4	32.1	13.7
Үндсэн хөрөнгө	782.7	1,035.6	252.9
Нийт хөрөнгө	807.7	1,072.1	264.4
Өр төлбөр		2.8	2.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	807.7	1,069.3	261.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	807.7	1,072.1	264.4

- Бараа материалын дансны үлдэгдэл 32.1 сая төгрөг болж 13.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 10.0 сая төгрөгийн хангамжийн материал худалдан авсан, 3.2 сая төгрөгийн үнэ төлбөргүй аж ахуйн материал нэмэгдсэн нь нөлөөлжээ.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,035.6 сая төгрөг болж 252.9 сая төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан 255.6 сая, урсгал төсвөөс худалдан авалтаар 97.6 сая, нийт 353.2 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 100.3 сая төгрөгийн элэгдлийн зардлаар буурсан нь нөлөөлсөн байна.

- Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,072.1 сая төгрөг болж 264.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.
- Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Засаг даргын тамгын газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 217.6 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нэмэлт санхүүжилт болон үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна.
- Тодруулбал үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 97.6 сая, тусламж санхүүжилтийн орлого 116.2 сая, туслах үйл ажиллагааны орлого 3.6 сая төгрөгөөр тайлант үед 217.6 сая төгрөг болж нэмэгдсэн нь үр дүнгийн тайлангийн орлого нэмэгдэхэд нөлөөлсөн байна.
- Нийт зардал өмнөх оноос 51.0 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин хөлс болон нэмэгдэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, бараа ажил үйлчилгээний зардал данс байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 770.5 сая төгрөгөөр, нийт зарлагыг 754.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 312.7 сая төгрөгөөр бууруулж 441.5 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2021 онд ковид-19 гарсантай холбогдуулан улс орон даяар өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 464.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 462.8 сая төгрөгийг урсгал зардал зарцуулж, 1.5 сая төгрөгийг буцааж төвлөрүүлсэн байна. Нийт зардлын 464.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсөв захирагчаас 2.2 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 31.4 сая, ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 104.3 сая нийт 137.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, бараа ажил үйлчилгээний бусад 134.7 сая төгрөгийг зарцуулж 3.2 сая төгрөгийн төсвийн үлдэгдлийг ТЕЗ дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

Тайлант онд Түвшинширээ сумын Засаг даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээнд зарцуулсан төсвийн гүйцэтгэл хангалттай гэж үнэлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагаа, тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээ, үйл явдал болон засаглах эрх бүхий этгээдүүдийн түвшин дэх харилцаатай холбоотой санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах асуудал гараагүй.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 132 мэдээлэл, хугацаа хоцорсон 15 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байгаа боловч зарим мэдээллийг хангалтгүй байршуулсан гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Түвшинширээ сумын Засаг даргын тамгын газарт "Итгэл" үзүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Засаг даргын тамгын газрын тайлант оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл, ажил гүйлгээ болон санхүүгийн тайланг тасалбар болгож гаргасан өдрөөс хойших үйл явдлыг шинжилж үзэхэд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 97,928.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 76,261.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,107.5 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоон, 20,559.5 мянган төгрөгийн 2 алдаа зөрчилд албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн.

бү

4.2 Төлбөрийн акт

Ажил олгочоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн хэмнэлт 1,107.5 мянган төгрөгийг хууль тогтоомжид заасны дагуу дээд шатны төсөвт төвлөрүүлэхгүйгээр харилцагч байгууллагад шилжүүлж авлага үүсгэсэн байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1¹, Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ./, 6.4.8² 7 дугаар зүйлийн 7.7³, 45 дугаар зүйлийн 45.2⁴ т заасныг тус тус зөрчсөнд төлбөрийн акт тогтоолоо. Энэ нь санхүүгийн тайлангийн болон ажил гүйлгээний иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

4.2 Албан шаардлага

- Тооллогын комисс эд хөрөнгө нэг бүрийг бодитой үнэлж, тоолоогүй, тооллогын дүнг нягтлан бодогчтой тулгаж, баталгаажуулаагүй, бараа материалын тайланг үнэн зөв бэлтгэж толилуулаагүй, материалыг нэр төрөл, тоо ширхгээр орлого авч зарлага болгоогүй, анхан шатны баримтыг стандартын дагуу хөтөлж тайлагнаагүй байна.
- Төсвийн хөрөнгөөр 7,752.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, 12,707.0 мянган төгрөгийн шагнал урамшуулал, спортын наадам, уралдаан тэмцээний, сонин сэтгүүлийн зардал гарган төсвийн хэмнэлтийн горимыг зөрчсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 , 16 дугаар зүйлийн 16.5.5⁵, 41 дүгээр зүйлийн 41.2.2⁶ , 41.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1⁷, 72.4.2⁸, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1⁹, 20 дугаар зүйлийн 20.2.3¹⁰, 20.2.6¹¹ дахь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4-т заасныг зөрчиж тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх

¹ /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах./,

² /төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх./,

³ / Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ./,

⁴ /Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ:/-

⁵ батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;/

⁶ /батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;/

⁷ эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах;

⁸ тоолсон эд хөрөнгийн үнийг бэлтгэн нийлүүлэгчийн дагалдах баримт, тухайн үеийн зах зээлийн үнийн жишигтэй тулган шалгаж, тооллогын бүртгэлд бичих;

⁹ Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.

¹⁰ холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;

¹¹ эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;

өртөггүй 136 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан “Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана” заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

2. Шилэн данстай холбоотой

2.1 Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудаст 261.3 сая төгрөгийн 15 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3-т заасан “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Түвшинширээ сумын ЗДТГ	6	97.9	1	76.3	1	1.1	2	20.5	2	-

